

ХОВД АЙМГИЙН ДАРВИ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “МОЭНКО” ХХК-ИЙН  
ХӨШӨӨТИЙН ЧУЛУУН НҮҮРСИЙГ ХУУРАЙ АРГААР БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН  
2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

---

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: (MV-001414, MV-001640,  
MV-006525, MV-004322, MV-011887, MV-020299, MV-011888, MV-015289)

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5141583

ХЯНАСАН:

ХБОБЗГ-ын ахлах шинжээч...../Ц.ЖАРГАЛНЭМЭХ/

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

“МОЭНКО” ХХК-ИЙН ЗАХИРАЛ..... /Ж.ОЮУНЧИМЭГ/

“МОЭНКО” ХХК

БАЙГАЛЬ ОРЧНЫ ОРЛОГЧ МЕНЕЖЕР:...../Б.ГАНБОЛД/

**АГУУЛГА**

**ЗУРГАН МЭДЭЭЛЭЛ** ..... 3

**ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЭЛ** ..... 4

**ГРАФИК МЭДЭЭЛЭЛ** ..... 4

**НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**..... 6

    1.1 Төслийн нэр: ..... 6

    1.2 Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:..... 6

    1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:..... 6

    1.4 Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ: ..... 6

    1.5 Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл: ..... 6

    1.6 Төслийн талбайн байршил: ..... 6

**ХОЁР. НҮҮРС БАЯЖУУЛАХ ТЕХНОЛОГИ** ..... 8

    2.1 Нүүрс баяжуулах үйлдвэр ..... 8

    2.2 Үйлдвэрийн ажиллах горим ..... 9

    2.3 Үйлдвэрийн технологи ..... 10

    2.4 Баяжуулалтын тоног төхөөрөмжийн ажиллах зарчим ..... 11

        2.4.1. ZM Хуурай баяжуулах төхөөрөмж ..... 11

        2.4.2. IDS рентгенээр ялгах төхөөрөмж..... 13

    2.5. Дэд бүтэц..... 15

        2.5.1. Усан хангамж..... 15

**ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ** ..... 22

    4.1 Техникийн шаардлага, зураг төслийн төлөвлөлтөөс бусад газарт ямар нэгэн ашиглалт хийхгүй байх. .... 25

    4.2 Ухаалаг баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтыг бууруулах салхинаас хамгаалах хаалт, хашаа барьж эхлэх: ..... 25

        4.2.1 Конвейераас буух нүүрсний тоосны тархалтыг бууруулахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ: ..... 27

        4.2.2 Ухаалга баяжуулах үйлдвэрээс үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор салхины хурдыг сааруулах чиглэлээр далан байгуулах ажлын хэрэгжилт:..... 28

        4.2.3 Технологийн замаас үүсэх тоосжилтыг бууруулах арга хэмжээний хэрэгжилт: 30

    4.3 Барилга байгууламжийн өмнө шимт хөрсний хуулалт хийж, хадгалалтыг шаардлагын дагуу явуулах..... 31

4.3.1 Барилгын талбарын цэвэрлэгээнээс гарах хог хаягдлыг зөвшөөрөгдсөн хогийн цэгт зөөвөрлөн хаяж зайлуулах.....	32
4.4 Хүйсийн говь, Цэцэг нуурын сав газрын захиргаатай ус ашиглах гэрээ байгуулж, ус ашигласны төлбөр төлөх .....	32
4.5 Тээвэрлэх, ачиж буулгах үйл ажиллагааны явцад санамсаргүй байдлаар хөрсөн дээр алдагдах, хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлж, аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллах. ....	33
4.6 Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах, гал түймэр, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулах 34	
4.7 Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг хуулинд заасан хугацаанд хийлгэх .....	35
<b>ДӨРӨВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....</b>	<b>38</b>
5.1 Одоогоор нөхөн сэргээлт хийх талбай байхгүй. ....	39
5.2 Төслийн эдэлбэр газрын хэмжээнд талбайн тохижилтыг хийж, халцарч зулгарсан хөрсөн гадаргуугийн хэмжээг багасгаж ногоон байгууламж байгуулах, мод тарих. ....	39
<b>ТАВ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b>	<b>40</b>
6.1 Гал түймэртэй тэмцэх багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж авах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний тоноглолуудыг зохих газарт байнга бэлэн байлгах. ....	41
6.2 Химийн бодисын хор аюул, түүнтэй хэрхэн харьцах, анхны тусламж, хамгаалах хэрэгсэл, галын аюулын үед авч хэрэгжүүлэх болон аюулгүй ажиллуулах сургалтанд хамруулах .....	42
6.3 Газар нутгийн налууг тооцсоны үндсэн дээр ус урсан орж барилгын суурь, газар доорх байгууламж зэргийг хэсэгчлэн болон тойруулан хаалт хийх. ....	43
<b>ЗУРГАА. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....</b>	<b>44</b>
7.1 Хог хаягдлын тооллого хийж, эх үүсвэр тус бүрээс жилд үүсэх хаягдлын төрөл, тоо хэмжээг нарийвчлан тогтоох: .....	46
7.2 Үйлдвэрээс зохих журмын дагуу материалыг бүрдүүлж хаягдлыг устгуулах тухай хүсэлтийг гаргаж байх.....	46
7.3 Ажиллагсадад хог хаягдлын хууль эрхзүйн орчин, хог хаягдлын менежментийн чиглэлээр сургалт зохион байгуулах .....	47
7.4 Ашиглалтаас гарсан аккумулятор, батерэйг нийлүүлэгчид буцаан тушаах эсхүл эрх бүхий байгууллагын удирдамжийн дагуу аюулгүй газарт хадгалах. ....	47
<b>ДОЛОО. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ (ОХШХ).....</b>	<b>50</b>

8.1 Хөшөөтийн уурхай орчмын уст цэгүүд болон Үенч голын ус, ҮГХТ, Булган голын уснаас дээж авч химийн ерөнхий шинжилгээг итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэх.....	52
8.2 Ажлын байрны дотоод орчны агаарын чанарыг тогтмол хэмжих. Хорт хий (CO <sub>2</sub> , NO <sub>x</sub> , SO <sub>x</sub> ),.....	52
8.3 Уурхай орчмын гадаад орчны агаарын чанарын /PM <sub>10</sub> , PM <sub>2.5</sub> тоос/ хэмжилтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх: .....	55
8.4 Ухаалаг баяжуулах үйлдвэрийн төсөл хэрэгжиж байгаа 1000.01 талбайгаас хөрсний бохирдлын мониторингийн хэмжилт хийх:.....	58
<b>НАЙМ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....</b>	<b>61</b>
<b>ЕС. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....</b>	<b>62</b>
10.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан .....	63
10.2, 10.3 Байгаль орчны чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажлыг олон нийтэд мэдээллэх.....	63

## **ЗУРГАН МЭДЭЭЛЭЛ**

<i>Зураг 1 Хөшөөтийн нүүрсний ордын байрилын зураг .....</i>	<i>7</i>
<i>Зураг 2. Нүүрс баяжуулах үйлдвэрийн ерөнхий төлөвлөлт .....</i>	<i>9</i>
<i>Зураг 3. Хуурай баяжуулах үйлдвэрийн технологийн схем .....</i>	<i>11</i>
<i>Зураг 4. Нүүрс хуурай аргаар баяжуулах ZM төхөөрөмж .....</i>	<i>12</i>
<i>Зураг 5. Нүүрс хуурай аргаар баяжуулах ZM төхөөрөмжийн бүдүүвч схем.....</i>	<i>13</i>
<i>Зураг 6. IDS рентгенээр ангилах төхөөрөмж.....</i>	<i>14</i>
<i>Зураг 7. IDS рентгенээр ангилах төхөөрөмжийн ялгалт хийх зарчим.....</i>	<i>15</i>
<i>Зураг 8. Усан хангамжийн худгуудын байриил.....</i>	<i>16</i>
<i>Зураг 9. Мананжуулагч буу.....</i>	<i>18</i>
<i>Зураг 10. Тоос дарах шүриших систем .....</i>	<i>18</i>
<i>Зураг 11. Салхины хаалт .....</i>	<i>19</i>
<i>Зураг 12. Ерөнхий план зураг .....</i>	<i>25</i>
<i>Зураг 13. Тоосжилтыг бууруулаж салхинаас хамгаалах хашаа .....</i>	<i>27</i>
<i>Зураг 14. Конвейераас буух нүүрсний тоос тархалтыг бууруулах арга хэмжээ .....</i>	<i>28</i>
<i>Зураг 15. Далан төлөвлөлтийн зураг .....</i>	<i>29</i>
<i>Зураг 16. Далан гүйцэтгэлийн зураг.....</i>	<i>30</i>
<i>Зураг 17. Усалгаа хийгдэж технологийн зам талбайн зураг.....</i>	<i>31</i>
<i>Зураг 18. Шимт хөрс хуулалт .....</i>	<i>31</i>

Зураг 19. Баяжуулах үйлдвэрийн барилгын явцын үед хог хаягдлын хяналт.....	32
Зураг 20. Шимт хөрс хуулалт. ....	33
Зураг 21. Онцгой байдлын ерөнхий газрын дэрэгдэх аврах 9-р ангиас сургалт.....	35
Зураг 22. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлт цахимаар гарсан. ...	37
Зураг 23. Ногоон байгууламж ажлыг ерөнхий төлөвлөлт.....	39
Зураг 24. Эмнэлгийн анхан шатны тусламжийн иж бүрэн, галын хор байруулсан байдал	42
Зураг 25. Барилга байгууламжийн ус зайлуулах суваг шуудууны байгууламж .....	43
Зураг 26. Хог хаягдлыг ангилан ялгаж пресслэсэн байдал.....	46
Зураг 27. Сургалтын үеийн зураг .....	47
Зураг 28. Аюултай хог хаягдал түр хадгалах талбайн .....	48
Зураг 29. Хөшөөтийн гол усны дээж авч шинжилгээнд явуулсан.....	52
Зураг 30. Уурхайн олборлох үйл ажиллагаанаас үүсэх PM10 тоосны тархалт, хоногийн дундаж (2025 оны 09 сарын 26-ны байдлаар) .....	56
Зураг 31. Уурхайн олборлох үйл ажиллагаанаас үүсэх PM10 тоосны тархалт, хоногийн дундаж (2025 оны 09 сарын 27-ны байдлаар) .....	57
Зураг 32. Уурхайн олборлох үйл ажиллагаанаас үүсэх PM10 тоосны тархалт, хоногийн дундаж (2025 оны 09 сарын 28-ны байдлаар) .....	58
Зураг 33. Хөрсний дээж авсан цэгүүд .....	59
Зураг 34. Хөрсний дээж авсан цэгүүд .....	60
Зураг 35. Дарви суманд зохион байгуулагдсан Мөрөн багийн ИНХ.....	63

## ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЭЛ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих талбайн солбилцол.....	8
Хүснэгт 2. Хуурай баяжуулах хэсгийн хүчин чадал, ажиллах горим .....	10
Хүснэгт 3. Гүний худгийн үзүүлэлт .....	16
Хүснэгт 4. Ажилчдын унд ахуйн хэрэглээний усны зарцуулалт.....	17
Хүснэгт 5. Жилд шаардагдах тенхологийн усны хэрэглээ.....	20
Хүснэгт 6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсвийн задаргаа .....	21
Хүснэгт 7. Далангийн ажил гүйцэтгэлийн тоон мэдээлэл.....	29

## ГРАФИК МЭДЭЭЛЭЛ

График 1. Халаалтын зуухнуудын бамбар утааны чиглэл дэх хүхэрлэг хийн 20 минутын дундаж агууламж.....	53
График 2. Халаалтын зуухнуудын бамбар утааны чиглэл дэх азотын давхар ислийн 20 минутын дундаж агууламж .....	53
График 3. Халаалтын зуухнуудын бамбар утааны чиглэл дэх нийт тоосны 20 минутын дундаж агууламж .....	54
График 4. Халаалтын зуухнуудын бамбар утааны чиглэл дэх нүүрстөрөгчийн дутуу ислийн 20 минутын дундаж агууламж .....	54
График 5. Халаалтын зуухнуудын орчмын шуугианы түвшин .....	55

## ОРШИЛ

Хөшөөтийн чулуун нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэр нь Ховд аймгийн Дарви сумын Мөрөн багийн нутагт Монгол Алтайн нурууны зүүн урд төгсгөлийн хойд хэсэгт, Улаанбаатар хотоос баруун тийш 1300 км, Ховд хотоос зүүн урагш 210 км, Дарви сумаас баруун урагш 50 км, Цэцэг сумаас хойш 29 км-ийн зайд оршино.

Хөшөөтийн чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төсөл нь нийт 1885.6 га талбайг хамарсан MV-015289, MV-011888, MV-011887, MV-006525, MV-004322, MV-001640, MV-001414, MV-020299 тоот ашиглалтын 8 тусгай зөвшөөрөлтэйгээр нүүрс олборлох үйл ажиллагаа явуулж байна.

Хөшөөтийн чулуун нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа нь байгаль орчин, уул уурхай, зам тээвэр, барилга, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй зэрэг нийгмийн салбарын бүхий л төрлийг хамарсан цогц хэлбэрээр явагдаж байгаа бөгөөд түүнтэй холбогдох хууль, журам, заавар, стандартуудыг мөрдөн ажиллаж байна.

Цаашид уурхайн үйл ажиллагаа өргөжих тусам байгаль орчны ажлуудыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай нягт хамтран ажиллах ба мөн олон улсын дэвшилтэт технологийг байгаль орчныг хамгаалах ажилд нэвтрүүлэн ажиллах болно.

МоЭнКо ХХК нь 2007 оноос өрөмдлөг хайгуулын ажил эхэлсэн бөгөөд энэ үеэс эхлэн Монгол улсын хууль тогтоомжийн дагуу байгаль хамгаалах чиглэлээр дараах ажлуудыг мэргэжлийн байгууллага болон компанийн дотоод нөөц бололцоогоор хийж гүйцэтгээд байна.

## НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Төслийн нэр:

Хөшөөтийн чулуун нүүрсний ордын нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэр

### 1.2 Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:

“МоЭнКо” ХХК

### 1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 4 дүгээр хороо, Сөүлийн гудамж 23, Түшиг төв, 3 давхар,  
Утас: (976)-7711-0567, (976)-9911-0170 Вэб хуудас: [www.moenco.mn](http://www.moenco.mn).

### 1.4 Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ:

Улсын бүртгэлийн дугаар: 9019023025

Улсын регистрийн дугаар: 5141583



### 1.5 Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл:

Хөшөөтийн нүүрсний уурхай нь (MV-015289, MV-011888, MV-011887, MV-006525, MV-004322, MV-001640, MV-001414, MV-020299) тоот ашиглалтын 8 тусгай зөвшөөрлийн 1885.6 га талбайг хамран үйл ажиллагаагаа явуулдаг. Нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэр нь 20 га талбайд үйл ажиллагаагаа явуулна.

### 1.6 Төслийн талбайн байршил:

Нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэр нь Ховд аймгийн Дарви сумын Мөрөн багийн нутагт Монгол Алтайн нурууны зүүн урд төгсгөлийн хойд хэсэгт оршино. Тус орд нь Улаанбаатар хотоос баруун тийш 1300 км, Ховд хотоос зүүн урагш 210 км, Дарви сумаас баруун урагш 50 км, Цэцэг сумаас хойш 29 км, Монгол Алтайн нурууны зүүн урд төгсгөлийн хойд хэсэгт далайн түвшнээс дээш 1900-2500 метр өндөрт оршдог.

**Баяжуулах үйлдвэрийн байршил**



Зураг 1 Хөшөөтийн нүүрсний ордын байршлын

## Хүснэгт 1. Төсөл хэрэгжих талбайн солбилцол

№	X	Y	Талбайн
1	523933.78	5185387.26	1000 га
2	523937.39	5184421.98	
3	523940.44	5183650.34	
4	523092.66	5183646.98	
5	523098.55	5182103.61	
6	523098.54	5181884.08	
7	520683.17	5181876.26	
8	520658.52	5185407.23	


**ХОЁР. НҮҮРС БАЯЖУУЛАХ ТЕХНОЛОГИ****2.1 Нүүрс баяжуулах үйлдвэр**

Нүүрс хуурай Баяжуулах үйлдвэр нь уурхайгаас 4 км, ажилчдын оффисоос 1.5 км зайд байрлана. Хөшөөтийн ордын нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэр нь:

- Нүүрс хүлээн авах хэсэг
- Хуурай баяжуулах үйлдвэрийн хэсэг
- Овоолгын талбайн хэсэг
- Оффис, сэлбэг материалын агуулах

Хуурай баяжуулах үйлдвэрийн нийт талбай 20 га байхаар төлөвлөсөн. Үүнд:

1. Анхдагч нүүрс хүлээн авах хэсэг
2. Хүдэр бэлтгэх хэсэг /бутлалт, шигшилт/
3. Нүүрс хуурай баяжуулах үйлдвэр
4. Баяжмалын овоолго
5. Сэлбэг материалын агуулах
6. Галын усны нөөцийн сав болон насос станц
7. Хаягдал чулуулаг буулгах хэсэг
8. Оффис
9. Цахилгаан үүсгүүрийн өрөө
10. Авто машины зогсох талбай зэрэг орно.



Зураг 2. Нүүрс баяжуулах үйлдвэрийн ерөнхий төлөвлөлт

## 2.2 Үйлдвэрийн ажиллах горим


Баяжуулах үйлдвэр нь жилд 330 хоног ажиллана, үйлдвэрийн цаг ашиглалтын коэффициентыг 85%-аар, техникийн бэлэн байдлыг 90%-аар тооцож урсгал засварыг цаг тухай бүрд хийж гүйцэтгэнэ. Үйлдвэр өдөрт 2 ээлжээр, 16 цаг ажиллана. Ээлж бүрд цэвэрлэгээ, үйлчилгээг хийж гүйцэтгэнэ. Баяжуулах үйлдвэрийн ажиллах горимын тооцооллыг дараах хүснэгтэд үзүүлээ.

## Хүснэгт 2. Хуурай баяжуулах хэсгийн хүчин чадал, ажиллах горим

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Дүн
1	Жилийн хуанлийн өдрийн тоо	хоног	365
2	Жилийн баяр ёслолын өдөр	хоног	4
3	Жилийн засвар үйлчилгээний хоног	хоног	31
4	Жилд ажиллах боломжит хоног	хоног	330
5	Хуурай баяжуулах үйлдвэрийн хүчин чадал	тн/цаг	950
6	Жилд ажиллах боломжит цаг	цаг	5280
7	Өдөрт ажиллах боломжит цаг	цаг	16
8	Хуурай баяжуулах үйлдвэрийн цаг ашиглалт	%	85%
9	Техникийн бэлэн байдлын коэффициент	%	90%
10	Хуурай баяжуулах үйлдвэрийн хүчин чадал	тн/хоног	15,200
	Баяжуулах нүүрсний хэмжээ	тн/жил	5,000,000
	Баяжуулсан баяжмалын хэмжээ	тн/жил	4,144,000

## 2.3 Үйлдвэрийн технологи

Хөшөөтийн нүүрсний уурхайн дээжид БНХАУ-ын Таншан Шенжоу компанид хийсэн хуурай аргаар баяжуулах хагас үйлдвэрлэлийн туршилтын үр дүнд үндэслэн технологийн сонголт, тооцооллыг хийсэн. Хуурай баяжуулах үйлдвэрийн хялбарчилсан технологийн схемийг зураг 3-д үзүүлээ.



Зураг 3. Хуурай баяжуулах үйлдвэрийн технологийн схем

## 2.4 Баяжуулалтын тоног төхөөрөмжийн ажиллах зарчим

### 2.4.1. ZM Хуурай баяжуулах төхөөрөмж

ZM серийн нүүрсийг ус ашиглахгүйгээр баяжуулах, өндөр үр ашигтай ангилах төхөөрөмж нь Tangshan Shenzhou Manufacturing Group компанийн олон жилийн судалгаа хөгжүүлэлт болон туршлагадаа суурилан боловсруулсан ухаалаг, хуурай аргаар боловсруулах технологийн хамгийн өндөр түвшинд хүрсэн бүтээгдэхүүн юм. Монгол улсад нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэрүүдийн түгээмэл ашигладаг FGX төхөөрөмжийн дараагийн боловсронгуй хувилбар юм. ZM хуурай баяжуулах төхөөрөмжийг зураг 4-д харуулав.




Зураг 4. Нүүрс хуурай аргаар баяжуулах ZM төхөөрөмж

#### Технологийн давуу тал

- Ангилах нарийвчлал өндөр-бие даасан ангилах зарчмаар ажилладаг, бусад ижил төрлийн төхөөрөмжөөс ангилах нарийвчлал өндөр
- Байгаль орчинд ээлтэй-тоног төхөөрөмж нь битүү орчинд ажилладаг, галд тэсвэртэй, үндсэн хэсгүүд нь дулаан болон дуу чимээ тусгаарлах материалаар хийгдсэн, тоос барих тоног төхөөрөмж нь байгаль орчинд ээлтэй
- Ухаалаг ажиллагааны түвшин өндөр-автомат удирдлагын системтэй, ухаалаг, хүний оролцоогүй процессын явцад хяналт тавих тохиргоотой
- Модульчилсан загвар-тоног төхөөрөмж нь бүхэлдээ ган бүтэцтэй, хэрэглэгчийн барилгын ажлын зардлыг бууруулна, угсрахад хялбар, ашиглалтад ороход хурдан

#### Ангилах зарчим

Энэ технологи нь нягтын зөрүүнд тулгуурлан ангилалт хийдэг. Ангилах давхарга бүр нь материалын нягтын зөрүүнд тулгуурлан ялган, ангилах тавцангийн дунд хэсэгт орсон материалыг дахин ангилах хэсэгт оруулж, гадаргуугийн нягтрал багатай материалыг давхаргаар нь ялган, өндөр нягтралтай материалын (хаягдал чулуу) мөргөлдөх, шахагдах хөдөлгөөнөөс үүссэн хөвөх нөлөөг ашиглан үе давхарга бүрд өөр өөр нягтралтай материал ялгах зарчмаар ажилладаг. ZM баяжуулах төхөөрөмжийн бүдүүвч схемийг зураг 5-т үзүүлээ.



Зураг 5. Нүүрс хуурай аргаар баяжуулах ZM төхөөрөмжийн бүдүүвч схем

#### 2.4.2. IDS рентгенээр ялгах төхөөрөмж

IDS рентгенээр ялгах төхөөрөмж нь Tangshan Shenzhou Manufacturing Group-ын бие даан бүтээсэн ухаалаг ангилах төхөөрөмж бөгөөд 25-300 мм хэмжээтэй нүүрс болон хаягдлыг ялгахад тохиромжтой. Энэхүү төхөөрөмж нь өгөгдөлд үндэслэн дүн шинжилгээ хийх замаар нүүрс болон хаягдлыг таних ухаалаг аргыг ашигладаг бөгөөд ангилах үр дүн өндөр, жигд ажиллагаатай, бүрэн автомат, хүний оролцоо багатай зэрэг давуу талуудтай. Энэхүү төхөөрөмж нь энгийн ажиллагаатай, ангилах өндөр нарийвчлалтай, засвар үйлчилгээ хийхэд хялбар, ус зарцуулдаггүй, эрчим хүч бага зарцуулдаг, тоног төхөөрөмж нь битүүмжлэгдсэн орчинд ажилладаг зэрэг давуу талтай. Тоног төхөөрөмж нь өндөр нарийвчлалтай тоос барих системтэй ба байгаль орчныг бохирдуулахгүй, байгаль орчны тогтоосон норм, шаардлагыг хангасан, нүүрс баяжуулах үйлдвэрт хэрэглэхэд тохиромжтой. IDS рентгенээр ялгах төхөөрөмж нь жигд тэжээх систем, туузандамжуулагч систем, рентген таних систем, дүрсээр байрлал тогтоох систем, өгөгдлийг цуглуулж боловсруулах болон үлээж гадагшлуулах систем, удирдлагын хяналтын систем зэрэг үндсэн 7 хэсгээс бүрдэхээс гадна хэмжилтийн систем, хурд хэмжих систем, тоос зайлуулах систем, цацрагийн хамгаалалтын систем, видео хяналтын систем, дохиоллын систем зэрэг 6 туслах системээс бүрдсэн.

#### Технологийн давуу тал

- Гараар ангилах ажлыг орлоно

- Бүхэл нүүрсийг усаар боловсруулах ажлыг орлоно
- Нүүрсний талбайн хаягдлыг ялгаж чанарыг сайжруулна
- Хаягдал дахь нүүрсний хэмжээг бууруулна
- ZM серийн боловсруулах тоног төхөөрөмжтэй хоршиж бүх төрлийн хэмжээтэй нүүрсийг ангилна, нүүрс бус түүхий эдийг ялгана.




Зураг 6. IDS рентгенээр ангилах төхөөрөмж

#### Технологийн давуу тал

1. Автоматаар таних, автоматаар үлээж ангилах, бүх процесст хүний оролцоо шаардагдахгүй.
2. АНУ-д үйлдвэрлэсэн хос рентген таних төхөөрөмж болон Швейцар улсад үйлдвэрлэсэн 3D камерыг ашиглан нүүрс таних өндөр нарийвчлалтай. Өгөгдлийг платформ дээр тооцоолон цэвэр нүүрс эсвэл хаягдлын байршлыг бодит цаг хугацаанд тодорхойлж, ангилдаг.
3. Үлээж ангилах нарийвчлал өндөр. Автомат үлээж ангилах механизм нь олон улсад нэр хүндтэй импортын өндөр давтамжийн үлээх хавхлагуудыг ашигладаг бөгөөд энэ нь үр ашигтай, тогтвортой бөгөөд миллисекундээс бага хугацаанд хариу үйлдэл үзүүлэх чадвартай
4. Ангилах программаа бие даан хөгжүүлэн суралцаж, ангилах материалын өөрчлөлтийн дагуу өгөгдлийг өөрөө тохируулах боломжтой бөгөөд боловсруулалтыг хамгийн үр дүнтэй хэмжээнд хүргэх боломжтой.
5. Өндөр стандартын аюулгүй байдлын хамгаалалтын хэрэгслээр тоноглогдсон, цацрагийн үзүүлэлт нь улсын стандартаас хамаагүй бага тул аюулгүй, байгаль орчинд ээлтэй.

6. Тоног төхөөрөмжийг хэрэгцээндээ нийцүүлэн тохируулах, "нүүрсийг үлээх" эсвэл "хаягдлыг үлээх" -ийг хэрэглэгчийн хэрэгцээнд тохируулан өөрчилж, үйл ажиллагааны зардлыг үр дүнтэй бууруулж болно.



Зураг 7. IDS рентгенээр ангилах төхөөрөмжийн ялгалт хийх зарчим


## 2.5. Дэд бүтэц

### 2.5.1. Усан хангамж

#### Усны эх үүсвэр

Нүүрс хуурайгаар баяжуулах үйлдвэрийн унд-ахуйн усны хэрэглээг Хөшөөт голын хөндийд орших гүний 3 худгаас усны машинаар зөөвөрлөн хангана. Тус 3 худаг нь одоо ашиглагдаж байгаа ба худгуудын үзүүлэлтүүдийг доорх хүснэгтэд үзүүллээ.

№	Худгийн нэр	Худгийн координат	Ашиглалтын ундрага, л/с	Насосны марк	Хүчин чадал, м <sup>3</sup> /цаг
1	Well-1	93 <sup>0</sup> 17'45.3" 45 <sup>0</sup> 50'9.04"	6.67	SEAR-NR-152-C/10	MAX 45
2	Well-2	93 <sup>0</sup> 17'12.6' 46 <sup>0</sup> 50'35.9"	9.2	SEAR-NS-95	MAX 30
3	PB-3	93 <sup>0</sup> 17'10.3" 46 <sup>0</sup> 50'24"	6	SEAR-NS-95E/34	MAX 10



Зураг 8. Усан хангамжийн худгуудын байршил

Хөшөөт голын хөндийд байгуулсан худгууд болон булгийн усны химийн шинжилгээг лабораторид шинжилгээ хийлгүүлж бүх үзүүлэлт нь ундны усны стандартыг хангаж унд ахуйд хэрэглэхэд тохиромжтой гэж тогтоосон байна.

Өөрөөр хэлбэл “Химийн бүрэлдэхүүнээрээ Гидрокарбонат ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр ус байна. Шинжилсэн бүх үзүүлэлтүүд нь ундны усны стандартын /MNS 900:2018/-н шаардлага хангаж байгаа учир хүний унданд хэрэглэхэд тохиромжтой” гэсэн дүгнэлтийг гаргасан байна.

### Гидрогеологи

Гидрогеологийн судалгааны ажлын хүрээнд 2007 онд Хөшөөтийн уурхайгаас 50 км радиустай талбайн хэмжээнд геофизикийн судалгаа явагдан, 5 газрын доорх устай талбайг ялган, 2015 оны байдлаар Ховд аймгийн Мөст сумын Боорчийн голын адгийн хөндий болон Хөшөөтийн голын хөндийд тус тус ашиглалтын нөөцийг батлуулсан байна. Хөшөөтийн

голын хөндийд 2008, 2011 онуудад өрөмдсөн 3 цооногт шавхалт туршилтын ажлыг гүйцэтгэн газрын доорх усны нөөцийг үйлдвэрлэлийн С зэргээр үнэлж 18.5 л/с буюу 1,598.4 м<sup>3</sup>/хоногоор Байгаль Орчин Ногоон Хөгжлийн Яамны (БОНХЯ)-ны Усны нөөцийн зөвлөлийн 2013.10.15 өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан. Энэ ашиглалтын нөөц нь одоогийн Хөшөөтийн уурхайн үйлдвэрлэлийн болон унд, ахуйн усны хэрэглээг бүрэн хангаж байна.

**Унд ахуйн усны хэрэглээ**

Ажилчдын унд ахуйн хэрэглээний усны зарцуулалтын дараах хүснэгтээр үзүүлээ.

*Хүснэгт 4. Ажилчдын унд ахуйн хэрэглээний усны зарцуулалт*

№	Ус ашиглах зориулалт	Ус ашиглах хүний тоо	Ус ашиглах стандарт (л/хүн*хоно)	Унд ахуйн усны хэрэглээ		
				Өдөрт ашиглах усны хэмжээ (м <sup>3</sup> /хон)	Жилд ашиглах усны хэмжээ (м <sup>3</sup> /жил)	Төслийн нийт хугацаанд ашиглах усны хэрэглээ, м <sup>3</sup>
1	Ажилчдын хэрэглээний ус ашиглалт	105	150	15.75	5,748.75	100,563.75

**Тоос дарах усны хэрэглээ**

Баяжуулах үйлдвэрийн дотор болон гадна овоолгын талбайн тоос дарах зориулалттайгаар технологийн усны хэрэглээ үүснэ. Баяжуулах үйлдвэрийн гадна байх овоолгын талбай нь нийт 10 га талбайг хамрах ба овоолго үүсгэх овоолгоос ачилт хийх явцад тоос үүсэх ба усны зарцуулалтыг бага байлгах технологийн судалгааг хийж гүйцэтгэв.

## Талбайн тоос дарах технологийн судалгаа

### Мананжуулагч

Мананжуулагч нь усыг маш нарийн ширхэгтэйгээр агаарт цацдаг усан буу юм. Агаарт дэгдэх тоосонцор руу цацсанаар тухайн хэсэгт үүсэх нарийн тоосыг манан хэлбэрийн усны дуслууд барьж буулгана. Мананжуулагч нь 40° хэлбэлзэлтэйгээр 100м хүртэл өндөр хүртэл манан үүсгэх давуу талтай. Мананжуулагч бууг дараах зурагт үзүүлээ.



Зураг 9. Мананжуулагч буу

### Тоос дарагч шүршигч

Овоолгын талбайд овоолго үүсгэгчээс үүсэх тоосыг тоос дарах зориулалтай шүрших системийн тусламжтай багасгана. Уг шүрших систем нь салхины хурд 10м/с-ээр дээш байх үед ажилладаг. Тоос дарах шүрших системийг механик тохируулгатай тоосжилт ихээр үүсэх үед ажиллуулах боломжтой. Овоолго үүсгэгчийн шилжих цэгүүдэд усны зарцуулалт багатай шүршигч суурилуулна. Шүрших системийг зураг 10-д харуулав.



Зураг 10. Тоос дарах шүрших систем

**Салхины хаалт**

Бүтээгдэхүүний овоолгын талбай, гаалийн хяналтын бүс зэрэгт салхинаас үүсэх тоосыг багасгах зорилгоор салхины хаалт суурилуулдаг. Салхины хаалт нь бүс нутгийн салхины урсгал чиглэлд тохируулан байгуулна. Салхины хаалт нь бат бэх сайтай бүрээс материалаар бүрсэн ган хүрээтэй тул хуй салхинд тэсвэртэй байна. Давуу тал арчилгаа бага, усны зарцуулалт байхгүй. Сул тал анхны хөрөнгө оруулалт өндөр, байгууламж дотор үүсэх тоосыг бууруулах боломжгүй мөн гаднаас үлээх салхийг хаах ч ачилт процессын явцад үүсэх тоосыг бууруулахгүй. Төсөл хэрэгжүүлэгч “МоЭнКо” ХХК-ийн одоо ажиллаж байгаа хуурай баяжуулах үйлдвэр уг аргыг ашиглаж байна.



*Зураг 11. Салхины хаалт*

**Овоолгын талбайг барьцалдуулах**

Эко сойл компанийн Монгол улсад нэвтрүүлж буй Дастлок Плас бүтээгдэхүүн нь байгалийн гаралтай органик нон-анионик полимер нэгдлийг овоолгын талбайг бүрснээр нягтруулах, барьцалдуулах технологи юм. Нүүрсний овоолго нь нар салхины хүчин зүйлээс хамаарч нүүрс амархан исэлдэлтэд ордог. Үүнээс хамгаалахын тулд овоолгын гадаргад цацалт хийснээр хамгаалалтын бүрхүүл үүсгэдэг. Ингэснээр овоолгын салхины алдагдалт, исэлдэлт шаталтаас бүрэн хамгаална. Уг технологийн сул тал нь хөрөнгө оруулалтын зардал өндөр, тоос дарах бодис нь ачилтын нүүрсний шинж чанарт нөлөөлж болзошгүй.

Тоос бууруулах дараах аргуудад харьцуулалт хийн төсөл захиалагчтай зөвлөлдсөний үр дүнд тоос бууруулах мананжуулагч ашиглахаар сонгов. Сонгосон тоос дарах аргын дагуу технологийн усны зарцуулалтыг тооцооллоо. Технологийн усны хэрэглээнд тоос дарах болон галын усны хэрэглээ орно. Тоос дарах усны хэрэглээг худгууд болон ил уурхайн шүүрэлтийн усаар хангана. Ил уурхайн шүүрлийн ус нь улирлын чанартай шүүрч ордог тул ашиглалтын тогтсон хэмжээг тооцох боломжгүй юм. Ил уурхайг ашиглах ТЭЗҮ-д тусгаснаар ил уурхайд  $1825.25 \text{ м}^3/\text{хоног}$  ус орж ирэхээр байна. Дараах хүснэгтэд төслийн технологийн усны хэрэглээг үзүүлэв.

Хүснэгт 5. Жилд шаардагдах тенхологийн усны хэрэглээ

<u>№</u>	Ус ашиглах зориулалт	Тоос дарах талбайн хэмжээ, м <sup>2</sup>	Ус ашиглах стандарт (L/м <sup>2</sup> *хон)	Унд ахуйн усны хэрэглээ	
				Өдөрт ашиглах усны хэмжээ (м <sup>3</sup> /хон)	Жилд ашиглах усны хэмжээ (м <sup>3</sup> /жил)
1	Баяжуулах үйлдвэрийн тоос дарах	8,000.0	2	16	3,280
				<b>16</b>	<b>3,280</b>

## Хүснэгт 6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсвийн зарцуулалт

№	Хийгдэх ажлын чиглэл	Төсвийн задаргаа,төг	Ажлын тоо
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	48,946,736	7
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-	2
3	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	7,307,440	3
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	-	4
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,350,000	4
6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	0	1
7	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчидад тайлагнах төлөвлөгөө	4,600,000	3
<b>Нийт</b>		<b>62,204,176</b>	<b>25</b>

### ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Барилгын ажлын үеийн агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	Техникийн шаардлага, зураг төслийн төлөвлөлтөөс бусад газарт ямар нэгэн ашиглалт хийхгүй байх.	Төслийн зам талбай	-	Барилгын ажлын хугацаанд	Техникийн шаардлага болон зураг төслийн дагуу төлөвлөгдөөгүй, тухайн зорилтот талбайгаас бусад газарт ямар нэгэн хэлбэрийн ашиглалт, үйл ажиллагаа явагдахгүй. Ингэснээр газар ашиглалтын хүрээнд зөрчил гарахаас сэргийлж, төлөвлөгдсөн бүтээн байгуулалт, инженерийн ажил зөвхөн багтагдсан зураг төслийн хүрээнд хийгдэж байна. Мөн байгаль орчны дүрэм журмын дагуу урьдчилан сэргийлэх хяналт, зохион байгуулалтыг тогтмол баримталж ажиллаж байна. <a href="#">Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.</a>	ЗТБХБЯ-ны сайдын “Барилгын норм ба дүрэм батлах тухай” 314 дүгээр тушаалын 2-р хавсралт, Үйлдвэрийн барилга БНБД 31-11-09
2		Ухаалаг баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтыг бууруулах салхинаас хамгаалах хаалт, хашаа барьж эхлэх	“МоЭнКо” ХХК	Үйл ажиллагааны зардал	Төсөл эхний жил	Тус хамгаалалтын хашаа нь 1186 м урт, 12 м өндөртэй, төмөр бетон суурьтай бөгөөд 1.6 м өндөр бетон ханан дээр тоосжилт бууруулах төмөр торон хийцтэйгээр баригдсан. Газар шорооны, суурь, бетон болон металл угсралтын ажлыг бүрэн гүйцэтгэж, ашиглалтад оруулсан.  <a href="#">Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.</a>	MNS 4585-2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982
3	Газрын гадарга, хэвлий, хөрсөн бүрхэвчийн бохирдол	Барилга байгууламжийн өмнө шимт хөрсний хуулалт хийж, хадгалалтыг шаардлагын дагуу явуулах	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардал	Барьж байгуулах ажлын эхэн үед	Ухаалаг баяжуулах үйлдвэрийн барилга байгууламжын зориулалтаар 51.63 га талбайгаас, 85,792.4 м3 шимт хөрсийг шинээр хуулж MNS 5916:2008 стандартын дагуу хадгалж байна.  <a href="#">Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.</a>	Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008
		Барилгын талбарын цэвэрлэгээнээс гарах хог хаягдлыг зөвшөөрөгдсөн хогийн цэгт зөөвөрлөн хаяж зайлуулах	Төслийн хэмжээнд	Үйл ажиллагааны зардал	Барилгын ажлын хугацаанд	Баяжуулах үйлдвэрийн барилгын ажил өрнөх хугацаанд үүссэн бүх төрлийн хог хаягдалд тогтмол хяналт тавьж ажилласан. Үүнд талбайн өдөр тутмын нөхцөл байдлыг шалган, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгуулах, талбайн цэвэрлэгээг тухай бүрд нь зохион байгуулаж, цуглуулсан хогийг уурхайн нэгдсэн хогийн цэгт тээвэрлэн зайлуулах ажлуудыг тасралтгүй гүйцэтгүүлсэн. Ийм байдлаар барилгын ажлын явцад орчны бохирдол үүсэхээс сэргийлж, хог хаягдлын зохистой менежментийг	-Хог хаягдлын тухай хууль

						ханган ажилласан. <a href="#">Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.</a>	
4	Төслийн үйл ажиллагаа, ус ашиглалтаас усны нөөц, чанарт үзүүлэх нөлөөлөл	Хүйсийн говь, Цэцэг нуурын сав газрын захиргаатай ус ашиглах гэрээ байгуулж, ус ашигласны төлбөр төлөх	Усан хангамжийн эх үүсвэр, шүүрлийн ус орчмын уст цэгүүд	23,946,736	Гэрээнд заасан хугацаа бүрт	Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргаа болон МоЭнКо ХХК-ийн хооронд “Ус ашиглах гэрээ” 2025 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн №02/2025 тоот гэрээг байгуулсан. Ус ашигласны төлбөрийг гэрээнд заасны дагуу унд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашигладаг Well-2, Well-3 дугаартай худгийн тоолуурын заалтыг үндэслэн сард нэг удаа Ховд аймгийн төрийн сангийн 160000944 тоот дансанд төлдөг. Мөн 2025 оны 08-р сарын 28-ны өдрийн E-2502-000021 дугаартай Ус ашиглуулах дүгнэлтийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас авсан. <a href="#">Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.</a>	Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс, ус ашиглах эрхийн бичгийн загварыг шинэчлэн батлах тухай (БОАЖС-ын 2018 оны 10 сарын 02-ны өдрийн А/376 дугаар тушаал)
5	Хөрсөн бүрхэвч	Тээвэрлэх, ачиж буулгах үйл ажиллагааны явцад санамсаргүй байдлаар хөрсөн дээр алдагдах, хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлж, аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллах	Төслийн хүрээнд	Үйл ажиллагааны зардал	Өдөр тутмын үйл ажиллагаанд	Ухаалаг баяжуулах үйлдвэрийн тэжээлийн болон буулгах талбайд хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор тухайн талбайн үржил шимт хөрсийг MNS 5916:2008 “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” стандартын шаардлагын дагуу урьдчилан хуулж, тусгайлсан шимт хөрсний овоолго үүсгэн хадгалж байна.  Мөн тээвэрлэх, ачиж буулгах үйл ажиллагааны явцад материал санамсаргүйгээр хөрсөнд асгарах, улмаар хөрсний бохирдол үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажилтнуудад аюулгүй ажиллагаа болон байгаль орчны хамгаалалтын зааварчилгааг тогтмол өгч, мөрдүүлэн ажиллаж байна.  Дээрх зааварчилгаа, журмын хэрэгжилтэд ХАБЭА ажилтан, талбайн мастер болон уулын инженерүүд тогтмол хяналт тавьж, өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдүүлэн ажиллаж байна. <a href="#">Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.</a>	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5859:2008 “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ” Байгаль орчны аудитын үл нийцэл


6	Хөдөлмөрийн аюулгүй байдал	Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах, гал түймэр, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулах	Төслийн бүх ажиллагсад	-	Жилд 1 удаа	Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчны хамгаалал, гал түймрийн аюулгүй байдал болон болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилтнуудад сургалт зохион байгуулж, аюулгүй ажиллагааны дүрэм, анхан шатны арга хэмжээ, хувийн хамгаалах хэрэгслийн зөв хэрэглээ болон байгаль орчныг хамгаалах үндсэн шаардлагуудыг танилцуулан мэдлэг олгох сургалтыг зохион байгууллаа. <a href="#">Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.</a>	-Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй тухай хууль. -Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 4992:2000 -Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг MNS 5029:2011 -Гал түймрээс хамгаалах. MNS 5566-2005
7	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгэх	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг хуулинд заасан хугацаанд хийлгэх	“МоЭнКо” ХХК	25,000,000	5 жил тутамд 1 удаа мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.	Хянан баталгааны ажилд шаардлагатай мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулж, тусгай зөвшөөрөлтэй "Аватар ХХК"-тай гэрээ байгуулан хянан баталгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. <a href="#">Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.</a>	Газрын тухай хуулийн 58-р зүйл Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам
<b>Сөрөг нөлөөллийг бууруулах нийт зардал, мян.төг</b>				<b>48,946,736</b>			



Тус хамгаалалтын хашаа нь 1186 м урт, нийт 12 м өндөртэй, төмөр бетон суурьтай, газрын хөрснөөс дээш 1.6 м өндөр цутгамал төмөр бетон ханатай, түүн дээр тоосжилтыг сааруулах зориулалтын төмөр торон хийцтэй байгууламж юм.

Ажлын хүрээнд газар шорооны ажил, суурь бэхэлгээ, бетон болон металл хийцийн угсралтын ажлуудыг гүйцэтгэж, байгууламжийг бүрэн ашиглалтад оруулсан.






*Зураг 13. Тоосжилтыг бууруулаж салхинаас хамгаалах хашаа*

4.2.1 Конвейераас буух нүүрсний тоосны тархалтыг бууруулахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Баяжуулсан нүүрс буух конвейерийн 8 цэгээс үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор INVT® серво мотор, Siemens® брэндийн S7-1200 PLC, мөн MCGS мэдрэгчтэй дэлгэц бүхий автомат удирдлагын системийг суурилуулсан.

Энэхүү систем нь радарын түвшин хэмжигч төхөөрөмжөөр нүүрсний овоолгын өндрийг тасралтгүй илрүүлж, өргөх хөшигний байрлалыг автоматаар дээш, доош тохируулан ажиллуулдаг. Үүний үр дүнд нүүрс буулгах үед үүсэх тоосны тархалтыг 50–60 хувиар бууруулах боломж бүрдсэн.




Зураг 14. Конвейераас буух нүүрсний тоос тархалтыг бууруулах арга хэмжээ

4.2.2 Ухаалга баяжуулах үйлдвэрээс үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор салхины хурдыг сааруулах чиглэлээр далан байгуулах ажлын хэрэгжилт:

Тоосноос хамгаалах даланг байршилд тохируулан 3 үе шаттайгаар байгуулахаар төлөвлөсөн. Далангийн эхний суурийг 15 метр өндөртэй барьж, дээд түвшнээс техник буулгалт хийх талбайн өргөн 26.73 метр, хамгаалах хөмсөгний өргөн 3 метр, өндөр 1.5 метр байхаар тооцоолон, ажлыг 3 хэсэгт хуваан гүйцэтгэж байна. Нэгдүгээр далангийн ажил 100% дууссан. Хоёрдугаар далангийн ажил 38%-тай, гуравдугаар далангийн ажил 20%-тай, нийт далангийн ажил 2026 оны 3 дугаар сарын 15-ны байдлаар 68%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Хүснэгт 7. Далангийн ажил гүйцэтгэлийн тоон мэдээлэл

Далангийн ажлын гүйцэтгэлийн мэдээ						
Нэр	Хэмжээ	-	03.01-03.07	03.08-03.14	Нийт	%
Далан-1	756,000	555,407	179,402	21,190	756,000	100%
Далан-3	300,000	-	-	59,196	59,196	20%
Далан-2	314,000	-	-	120,579	120,579	38%
Нийт	1,370,000	555,407	179,402	200,964	935,774	68%
		41%	13%	15%	68%	68%



Зураг 15. Далан төлөвлөлтийн зураг



*Зураг 16. Далан гүйцэтгэлийн зураг*

#### 4.2.3 Технологийн замаас үүсэх тоосжилтыг бууруулах арга хэмжээний хэрэгжилт:

Технологийн зам талбайн усалгааг өдөр бүр тогтмол зохион байгуулан гүйцэтгэж байна. Замын тоосжилтыг бууруулах, орчны нөлөөллийг багасгах зорилгоор Алтайн зам ХК болон Мезом ХХК-ийн 20–40 тоннын багтаамжтай 4 усны машин өдөр, шөнийн ээлжээр ажиллаж, 24 цагт 600–700 тонн ус ашиглан зам талбайд усалгаа тогтмол хийж хэрэгжүүлж байна.



Зураг 17. Усалгаа хийгдэж технологийн зам талбайн зураг

4.3 Барилга байгууламжийн өмнө шимт хөрсний хуулалт хийж, хадгалалтыг шаардлагын дагуу явуулах

Ухаалга баяжуулах үйлдвэрийн барилга байгууламж болон авто замын зориулалтаар 57.25 га талбайгаас, 87,297.4 м<sup>3</sup> шимт хөрсийг шинээр хуулж MNS 5916:2008 стандартын дагуу хадгалж байна.



Зураг 18. Шимт хөрс хуулалт

4.3.1 Барилгын талбарын цэвэрлэгээнээс гарах хог хаягдлыг зөвшөөрөгдсөн хогийн цэгт зөөвөрлөн хаяж зайлуулах

Баяжуулах үйлдвэрийн барилгын ажил өрнөх хугацаанд үүссэн бүх төрлийн хог хаягдалд тогтмол хяналт тавьж ажиллав. Үүнд талбайн өдөр тутмын нөхцөл байдлыг шалган, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгуулах, талбайн цэвэрлэгээг тухай бүр зохион байгуулж ойролцоогоор 120 гаруй тонн хог хаягдлыг цуглуулан нэгдсэн хогийн цэгт тээвэрлэн зайлуулах ажил дээр хяналт тавьж тасралтгүй гүйцэтгүүлсэн.

Ийм байдлаар барилгын ажлын явцад орчны бохирдол үүсэхээс сэргийлж, хог хаягдлын зохистой менежментийг ханган ажилласан.



Зураг 19. Баяжуулах үйлдвэрийн барилгын явцын үед хог хаягдлын хяналт

4.4 Хүйсийн говь, Цэцэг нуурын сав газрын захиргаатай ус ашиглах гэрээ байгуулж, ус ашигласны төлбөр төлөх

Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргаа болон МоЭнКо ХХК-ийн хооронд “Ус ашиглах гэрээ” 2025 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн №02/2025 тоот гэрээг байгуулсан. Ус ашигласны төлбөрийг гэрээнд заасны дагуу унд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашигладаг Well-2, Well-3 дугаартай худгийн тоолуурын заалтыг үндэслэн сард нэг удаа Ховд аймгийн төрийн сангийн 160000944 тоот дансанд төлдөг. Мөн 2025 оны 08-р сарын 28-ны

өдрийн E-2502-000021 дугаартай Ус ашиглуулах дүгнэлтийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас авсан.

2025 оны 10 сарын 31-ний байдлаар Хөшөөтийн уурхай унд-ахуйн хэрэгцээнд 17,688 м<sup>3</sup> ус ашиглаж, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу 1,558,318 төгрөг төлсөн.

Үйлдвэрлэлийн зориулалтаар 91,975.11 м<sup>3</sup> гүний ус хэрэглэж 17,341,228 төгрөг, мөн 6,527 м<sup>3</sup> шүүрлийн усыг шавхан зайлуулж зам талбайн тоосжилт, ногоон байгууламжийн усалгаа, галын аюулын сургалт, өрөмдлөгийн ажилд ашигласны төлбөрт 4,144,906.08 төгрөг төлсөн.

Ингэснээр МоЭнКо ХХК нь 2025 онд ус ашиглалттай холбоотой нийт 23,946,736 төгрөгийн төлбөрийг холбогдох журмын дагуу төлсөн байна.

4.5 Тээвэрлэх, ачиж буулгах үйл ажиллагааны явцад санамсаргүй байдлаар хөрсөн дээр алдагдах, хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлж, аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллах.

Ухаалаг баяжуулах үйлдвэрийн тэжээлийн болон буулгах талбайд хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор тухайн талбайн үржил шимт хөрсийг MNS 5916:2008 “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” стандартын шаардлагын дагуу урьдчилан хуулж, тусгайлсан шимт хөрсний овоолго үүсгэн хадгалж байна.

Мөн тээвэрлэх, ачиж буулгах үйл ажиллагааны явцад материал санамсаргүйгээр хөрсөнд асгарах, улмаар хөрсний бохирдол үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажилтнуудад аюулгүй ажиллагаа болон байгаль орчны хамгаалалтын зааварчилгааг тогтмол өгч, мөрдүүлэн ажиллаж байна.

Дээрх зааварчилгаа, журмын хэрэгжилтэд ХАБЭА ажилтан, талбайн мастер болон уулын инженерүүд тогтмол хяналт тавьж, өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдүүлэн ажиллаж байна.



Зураг 20. Шимт хөрс хуулалт.

#### 4.6 Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах, гал түймэр, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулах

Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчны хамгаалал, гал түймрийн аюулгүй байдал болон болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хуурай баяжуулах үйлдвэрийн 108 ажилтанд давхардсан тоогоор нийт 432 ажилтан хамрагдалттай сургалтыг зохион байгуулсан.

*Үндсэн сэдвүүд:*

- Аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа
- Хамгаалах хэрэгслийн төрөл, зөв хэрэглээ
- Анхны тусламж
- Онцгой байдлын үеийн арга хэмжээ, бэлэн байдал

Мөн уурхайн ажилтнуудад Гамшгаас хамгаалах тухай болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиудын хэрэгжилтийг хангах, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор онол-практик хосолсон сургалтыг батлагдсан сургалт, дадлагын хөтөлбөрийн дагуу зохион байгууллаа.

*Сургалтын үеэр дараах чиглэлүүдээр мэдлэг олгов. Үүнд:*

- Ажлын байрны аюулыг илрүүлэх, мэдээлэх арга
- Аюулын дүн шинжилгээ хийх
- Ажлын байрны нөхцөл, тоостой тэмцэх арга хэмжээ
- Эрүүл мэндэд хор нөлөө, урьдчилан сэргийлэлт
- Болзошгүй гамшиг, ослын эрсдэлийг бууруулах арга
- Аюул, осолд дөхсөн тохиолдлын хяналт
- Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт

Сургалтыг Онцгой байдлын Ерөнхий газрын дэргэдэх Уул уурхайн аврах 09 дүгээр ангийн 6 алба хаагч 2025 оны 11 дүгээр сарын 20–21-ний өдрүүдэд Хөшөөт уурхайн байршилд зохион байгуулж, Мо Эн Ко ХХК-ийн сайн дурын бүлгэмийн 20 гишүүн хамрагдав.





Зураг 21. Онцгой байдлын ерөнхий газрын дэрэгдэх аврах 9-р ангиас сургалт.

#### 4.7 Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг хуулинд заасан хугацаанд хийлгэх


МоЭнКо ХХК-ийн үйл ажиллагаа явуулж буй төслийн талбайн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны хугацаа 2025 онд дуусаж байгаатай холбогдуулан уг хянан баталгааны ажлыг зохион байгууллаа. Ажлыг “Газрын тухай” хуулийн 58 дугаар зүйл, Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор баталсан “Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх журам”, мөн Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 34 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралтад заасан “Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын заавар”-ын дагуу гүйцэтгэсэн.

Хянан баталгааны хүрээнд тусгай зөвшөөрөлтэй талбайн газар ашиглалт, хөрсний хэв шинж, ангилал, ургамлын бүлгэмдэл, хөрсний эвдрэлийн хэмжээ, гадаргын өнөөгийн байдал болон байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг тодорхойлон үнэлж, дүгнэлт гаргав.

Ажлыг гүйцэтгэх мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулж, тусгай зөвшөөрөлтэй “Аватар” ХХК-тай гэрээ байгуулан хянан баталгааны ажлыг хийлгэв.

Жишээ болгож “Газрын төлөв байдлын, чанарын хянан баталгааны нэгж талбайн сүлжээний зураг болон Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны цахимаар гарсан дүгнэлтийг орууллаа.

Ховд /84/ аймгийн Дарви /13/ сумын нутагт байрлах "МОЭНКО" ХХК-ийн ашиглах эрхийн үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газрын зориулалттай газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зураг



**Таних тэмдэг**

- Эргэлтийн цэг
- Дэж авсан цэг
- Бичиглэл хийсэн цэг
- Зөвшөөрөлтэй нэгж талбарын хил
- 8401000671 / 1000 га
- 8401000671 - Нэгж талбарын дугаар 1000 га - Талбайн хэмжээ, га

**Газар ашиглалт**

- Аж ахуйн хашаа
- Дэд станц
- Засварын газар
- Нүүрс баяжуулах талбай
- Нүүрс баяжуулах үйлдвэр
- Нүүрс буулгах талбай
- Нөлөөлдөг өртсөн талбай
- Уурхайн дотоод зам
- Уурхайн оффис
- Хөрсний овоолго
- Уерийн далан
- Сул чөлөөтэй талбай

**Эрээлтийн цэг**

Нэгж талбарын дугаар/талбайн хэмжээ, га	Цэгийн дугаар	Газарзүйн солбицол Уртраг	Өргөрөг
1	93° 18' 49.570"	46° 48' 17.760"	
2	93° 18' 49.588"	46° 48' 46.488"	
3	93° 18' 49.557"	46° 48' 21.488"	
4	93° 18' 5.557"	46° 48' 21.488"	
5	93° 18' 8.555"	46° 47' 31.488"	
6	93° 18' 8.514"	46° 47' 24.378"	
7	93° 18' 15.588"	46° 47' 24.488"	
8	93° 16' 14.987"	46° 49' 18.802"	

**Дэж авч, бичиглэл хийсэн цэг**

Хүнд металл, эрүүл ахуй	1	93.30697	46.80993
Агрохими, хүнд металл	2	93.30014	46.79975
Агрохими, хүнд металл	3	93.29833	46.82081
Агрохими, хүнд металл	4	93.28167	46.79514
Агрохими, хүнд металл	5	93.27322	46.81488
Хүнд металл, эрүүл ахуй	6	93.30014	46.81678
	1	93.2830556	46.7928078
	2	93.2920556	46.8208111
	3	93.30014	46.79975
Ургамлын бичиглэл	4	93.27322	46.81488

**Хөрсний механик бүрэлдэхүүн**

Дэж №	Гүн, см	Механик ширхгүүд, % ширхийн хэмжээ, мм							Механик бүрэлдэхүүн
		0.25	0.05	0.01	0.005	0.001	<0.001	Ф.01	
2	0-15	1.8	67.3	18.6	9.8	5.3	7.2	22.3	х.ш
	15-22	2.3	62.9	12.9	8.2	7.5	6.4	22.1	х.ш
3	0-14	1.3	51.5	22.6	9.5	5.2	8.9	24.6	х.ш
	14-30	3.6	55.3	16	10	6.1	7	23.1	х.ш
4	0-10	0	47.3	26.3	12.7	9.1	4.6	26.4	х.ш
	10-20	4.4	60.2	20	9.8	10	5.6	25.4	х.ш
5	0-15	2.3	52.3	21.3	9.8	8.2	6.1	24.1	х.ш
	15-25	0	45.2	26.9	14.3	6.3	7.3	27.9	х.ш
6	0-20	7.3	62.8	13.6	8.6	2.6	5.1	16.3	эпсанар

**Хөрсний агрохими шинж чанар**

Дэж №	Гүн, см	рН	Давс, %	ЦДН, d/m	Ялгам, %	СаСО <sub>3</sub>	Шингээгдсэн суурьт азот, мг/100г		Шам тэжээлийн элементүүд, мг/100г		
							Ca	Mg	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O	С
2	0-15	8.20	0.107	0.255	2.31	1.64	17	4	3.06	16	
3	0-14	8.25	0.048	0.116	2.76	0.8	23	3	2.8	12	
4	0-10	8.47	0.21	0.5	1.84	1.44	18	6	4.1	14.8	
5	0-15	8.37	0.066	0.159	1.62	1.92	29	7	2	6.8	
	15-25	8.46	0.064	0.153	0.86	1.28	12	9	2.68	2.8	
6	0-20	8.34	0.062	0.148	1.46	1.14	13	7	2.4	12	

**Хөрсний хүнд металлын хэмжээ**

Дэж №, байршил	Гүн, см	Хөрсөн дэх хүнд металлын агууламж, %									
		As	Cd	Pb	Zn	Cu	Zn	Cr	Co	Mo	Ag
1	0-20	1.85	ND	3.55	0	15	60				
2	0-15	0.75	ND	14.3	0	3.85	16.7				
3	0-14	8.95	ND	10.7	0.85	40	20				
4	0-10	1.1	ND	10.7	0	3.8	13.35				
5	0-15	4.85	ND	7.15	0.3	2.9	20				
Шавранцар хөрсөнд	100	1.5	70	80	150	100					
6	0-20	6.7	ND	3.55	9.8	8.2	21.2				
Эпсанцар хөрсөнд	60	1	50	60	100	60					

**Хүндхэн агууламж /MNS 5850:2019/**

Уургалын бүрэлдэхүүн төрөл байдал	Уургалын бүрэлдэхүүн төрөл байдал	Уургалын бүрэлдэхүүн төрөл байдал	Уургалын бүрэлдэхүүн төрөл байдал	Уургалын бүрэлдэхүүн төрөл байдал
1	2	3	4	5
6	7	8	9	10
11	12	13	14	15
16	17	18	19	20
21	22	23	24	25
26	27	28	29	30
31	32	33	34	35
36	37	38	39	40
41	42	43	44	45
46	47	48	49	50
51	52	53	54	55
56	57	58	59	60
61	62	63	64	65
66	67	68	69	70
71	72	73	74	75
76	77	78	79	80
81	82	83	84	85
86	87	88	89	90
91	92	93	94	95
96	97	98	99	100

Газрын төлөв байдлын, чанарын хянан баталгааны нэгж талбайн сүлжээний зураг

ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ХЯНАН БАТАЛГААНЫ ДҮГНЭЛТ 1

**ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ХЯНАН БАТАЛГААНЫ ДҮГНЭЛТ**

Хянан баталгааны төрөл: Захиалгат **Огноо: 2025-11-25 15:45:40**

1. Газар эзэмшигч: "МоЭНКО" ХХК **Сум(дүүрэг): Дарви**

2. Аймаг (нийслэл): Ховд

3. Байршил: Маран 3-р баг, Салхит ам, 1

4. Нэгж талбарын дугаар: 8401000671

5. Хөрсний нэр: Чулуураг цайвар хүрэн /1503/, Сайрын нимгэн цайвар хүрэн /1503/

6. Ургамалжилт: Агь-ерхөг-бүнгийн харганат, крыловын хялгана-ерхөгт /Ө-IV-1-2/

7. Нийт талбайн хэмжээ: 10000136 м<sup>2</sup> /1000.01 га/

8. Газар ашиглах зориулалт: Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар

9. Одоогийн газар ашиглалтын хэлбэр: Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар

10. Газар ашиглах, эзэмших шийдвэр: Сумын Засаг даргын 2010 оны 07-р сарын 05-ны өдрийн 73 тоот шийдвэр

11. Газар ашиглах эрхийн гэрчилгээний дугаар: 0000120058

12. Эзэмшил газрын төлөв байдал, чанарын тодорхойлолт:

Талбайн нэр	Талбайн хэмжээ, м2	Үүнээс эдвэрч бохирдсон талбай		
		Физикийн	Химийн	Биологийн
Нийт эзэмшил талбай	10000007	-	-	-
Нэгж талбарын талбай	10000007	-	-	-
Газар дээр ашиглаж байгаа талбай	10000007	-	-	-
Илүү ашиглаж байгаа талбай	-	-	-	-
Дутуу ашиглаж байгаа талбай	-	-	-	-
А. Зөвшөөрөлтэй ашиглаж байгаа талбай	10000007	-	-	-
1. Үйл ажиллагаанд өртөөгүй талбай	7821967	-	-	-
Үүнээс   Сул чөлөөтэй талбай	7821967	-	-	-
2. Үйл ажиллагаанд өртсөн талбай	2178040	+	-	-
Аж ахуйн хашаа	51400	+	-	-
Дэд станц	9395	+	-	-
Засварын газар	100801	+	-	-
Нүүрс баяжуулах талбай	48729	+	-	-
Нүүрс баяжуулах үйлдвэр	54378	+	-	-
Нүүрс буулгах талбай	47256	+	-	-
Уурхайн дотоод зам	172913	+	-	-
Уурхайн оффис	21768	+	-	-
Уерийн далан	4135	+	-	-
Хөрсний овоолго	1349522	+	-	-
Нөлөөлдөг өртсөн талбай	317743	+	-	-

**13. Газрын гадарга, төлөв байдал:**

Газрын гадарга уулын бэл хажуу бүхий налууутар, уулс хоорондын хөндийн талархаг, бага эргийн толгодорхог, 0-5 градусын хэвгий гадаргатай бөгөөд далайн түвшнээс дээш 1890-2016м өндөрт оршино. Тус нэгж талбарт "Хөшөөт"-ийн уурхай ашиглахтай холбоотой дэд бүтцийн бүтээн байгуулалт, барилга байгууламжууд байгуулагдсан. Талбайн зүүн болон зүүн хойд хэсэг нь уурхайн нүүрс олборлолт, тээвэрлэлийн үйл ажиллагааны дам нөлөөлдөг өртсөн бөгөөд нүүрс баяжуулах үйлдвэр, нүүрс ачиж буулгах талбай, хөрсний овоолгын талбай гадаргын эвдрэл, төрх байдлын өөрчлөлттэй болсон. Талбайн урд талд байгаль орчинд ээлтэй, битүүмжлэгдсэн, бүрэн автомат технологи бүхий Хуурай баяжуулах үйлдвэрийн барилга урсгалтын ажил болон дагалдах бусад дэд бүтцийг барьж байгуулж, туршилтын ажил хийгдэж байна. Талбайн баруун болон хойд хэсэг нь

ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ХЯНАН БАТАЛГААНЫ ДҮГНЭЛТ 2

Газрын гадарга төрх байдлын өөрчлөлтгүй, уурхайн үйл ажиллагааны нөлөөлдөг өртөөгүй, байгалийн нөхцөлөөрөө байна. Талбайн зүүн урд болон урд хэсэгт хүний үйл ажиллагааны нөлөөллийн эрчим бага туссан хөрсөн бүрхэвч нь бага зэрэг талхлагдсан байна.

**14. Хөрсний доройтол, бохирдолт, түүний төрөл, зэрэглэл:**

Нэгж талбарын баруун болон төв, хойд хэсэг нь газрын гадарга төрх байдлын өөрчлөлтгүй, уурхайн үйл ажиллагааны нөлөөлдөг өртөөгүй, харьцангуй хэвгий багатай, тэгшвтэр гадаргуутай энэ хэсэгт ихэнхдээ Чулуураг болон сайрагхар цайвар хүрэн мөн элсэн хуучаастай цайвар хүрэн, элсэнцэр, хөнгөн шавранцар цайвар хүрэн зэрэг дэд хэв шинжийн хөрс зонхилон тархана. Элдээр хөрс нь ашиглалтын нөлөөнөөс хамаарч харилцан адилгүй хэмжээтэй талхагдалд болон эвдрэлд орсон байна. Салхит ам нэртэй газрын өргөн хөндийн гадаргуугийн арай нам түвшинд хүрэн хөрстэй хиллэж цайвар хүрэн хөрс тархана. Талбайд тархсан хөрсний механик бүрэлдэхүүнийг элс, тоос, шаврын харьцаагаар тодорхойлоход элсэн фракц 1-0.05мм –ийн А өнгөн үеийн хэмжээ 45.2-70.1% тоосон фракц 0.05-0.001 мм –ийн хэмжээ 24.8-48.1% шавар фракц <0.001мм-ийн хэмжээ 4.6-9.9% хооронд байх ба тухайн хөрсийг механик бүрэлдэхүүний олон улсын гурвалжны аргаар тодорхойлоход 0.01мм-ээс бага диаметртэй физик шаврын хэмжээ 16.3-26.4% буюу элсэнцэр болон хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй хөрс байна. 2020 оны шинжилгээний дүнтэй харьцуулахад үйл ажиллагаанд өртөөгүй хэсэгт авсан цэгүүдэд ялзмагт үеийн зузаанаас хамааран хөрсний физик шаврын хэмжээ 2.9% хүртэл өссөн үзүүлэлттэй байна.

**Хөрсний механик бүрэлдэхүүн**

Дээжийн дугаар	Дэж авсан гүн /см/	Механик ширхгүүд, % ширхийн хэмжээ, мм						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	
2020 оны шинжилгээний дүн								
ХӨ-20-03	0-20	16.2	50.1	17.4	2.9	7.6	5.8	16.2
ХӨ-20-04	0-20	6.2	54.0	18.3	4.7	9.3	7.6	21.5
ХӨ-20-05	0-20	1.9	56.1	23.1	7.6	6.8	4.4	18.8
ХӨ-20-07	0-20	14.3	49.6	18.1	7.4	6.1	4.5	18.0
ХӨ-20-12	0-20	8.6	47.6	20.3	8.4	6.4	8.7	23.5
ХӨ-20-13	0-20	11.3	59.5	11.6	4.6	6.8	6.2	17.7
2025 оны шинжилгээний дүн								
Дэж-8	0-15	1.8	57.3	18.6	9.8	5.3	7.2	22.3
	15-22	2.5	62.5	12.9	8.2	7.5	6.4	22.1
Дэж-14	0-14	1.3	51.5	22.6	9.5	5.2	9.9	24.6
	14-30	3.6	55.3	18	10	6.1	7	23.1
Дэж-15	0-10	0	47.3	26.3	12.7	9.1	4.6	26.4
	10-25	4.4	50.2	20	9.8	10	5.6	25.4
Дэж-16	0-15	2.3	52.3	21.3	9.8	8.2	6.1	24.1
	15-25	0	45.2	26.9	14.3	6.3	7.3	27.9
Дэж-18	0-20	7.3	62.8	13.6	8.6	2.6	5.1	16.3

